



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.25 № 02/40 ЧАТ-САТ/2013/18/СТНА-ТСС  
Хөрөнгийн тооллого хийх тухай

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Хүүхдийн төлөө сангийн 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2012 оны жилийн эцэст 7,944.5 мянган төгрөгийн бараа материал, 159,254.9 мянган төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийг тооллого хийж баталгаажуулаагүйгээр санхүүгийн тайланд тусгаж бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11.2.1 дүгээр заалтад “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллогыг заавал хийнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11.2.1, 19.1.4, ТБОНӨТХуулийн 70 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3, “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн дараах Албан шаардлага өгч байна. Үүнд:

Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг 2013 оны 4 дүгээр сарын 01-ний дотор хийж, хариуг УАГ-т мэдэгдэх, хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллахыг Хүүхдийн төлөө сангийн дарга И.Нарантуяа, нягтлан бодогч Г.Ганням нарт шаардаж байна.

Энэхүү албан шаардлагын биелэлтийг 2013 оны 6 дугаар сарын 25-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР**



**Г.ЮРА**

078118